



ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2024 оны 10-р сарын 30-ны өдөр

№ 51

Улаанбаатар хот

Хаалттай хүрээнд үнэт цаас гаргах тухай

Компанийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3, 76 дугаар зүйлийн 76.1.5 дах заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх заалт, “Инвескор ББСБ” ХК (цаашид “Компани” гэх)-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.1, 9 дүгээр зүйлийн 9.6.22 дах заалтыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

- Компани нь нийт 50,000,000,000.00 (тавин тэрбум) төгрөг хүртэлх үнийн дүн бүхий бонд (цаашид “Хаалттай бонд” гэх)-ыг хөтөлбөр байдлаар биржийн бус зах зээлд хаалттай хүрээнд санал болгон дараах нөхцөлөөр арилжаалахаар гаргахыг зөвшөөрсүгэй. Үүнд:

Гаргах хэлбэр	Хаалттай хүрээнд
Татан төвлөрүүлэх дүн	50,000,000,000.00 (тавин тэрбум) төгрөг хүртэлх
Бондын нэг бүрийн нэрлэсэн үнэ	1,000,000.00 (нэг сая) төгрөг
Гаргах бондын тоо ширхэг	50,000,000 (тавин сая)
Бондын хугацаа	18 сар хүртэл
Бондын хүү, төлөх давтамж	16-18% (жилийн), улирал тутам
Үндсэн төлөлт	Хугацааны эцэст

- Хаалттай бондыг биржийн бус зах зээлд хэсэгчлэн гаргаж арилжаалах бөгөөд хэсэгчлэн гаргах хугацаа, хэмжээ болон бондын хүүг тухай бүр тогтоох, андеррайтер сонгож гэрээ байгуулах бүрэн эрхийг Компанийн Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д олгосугай.
- Энэхүү тогтоолын хэрэгжилтийг хангахтай холбоотой шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Компанийн Гүйцэтгэх захирал /Д.Баясгалан/-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

